

Дундговь аймгийн Засаг даргын Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдтай 2024 онд хамтран ажиллах гэрээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 23

Мандалговь хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг сайжруулж, цаашид гарах үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ


Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдтай байгуулсан аймгийн Засаг даргын хамтран ажиллах гэрээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг дарга хамтран ажиллах гэрээгээр 15 үүргийг хүлээж, үүргийг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган үр дүнг тооцож ажилласнаар жилийн эцсээр арга хэмжээний хэрэгжилтийн гүйцэтгэлийн дундаж 99,3 хувьтай байна.

ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:

Цахим засаглалын бодлогыг “Цахим аймаг-Ухаалаг Дундговь” цогц арга хэмжээний хүрээнд аймгийн болон сумдын цахим хуудсыг шинэчлэн мэдээллийн ил тод байдлын 98 шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг цахим хуудсанд байршуулж 2024 оны эцсийн байдлаар 99,71 хувьтай байна.



Аймгийн хэмжээнд 15 байгууллагын 64 үйлчилгээ цахимжсан ба “И-Монгол академи” Улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран E-Mongolia системд нэвтэрсэн 28 үйлчилгээг дахин загварчилж, шинээр нэвтрүүлэх 22 үйлчилгээний судалгааг нэгтгэн цахимжуулсан.



Төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран 24/7 цагаар ажиллах ухаалаг төвд 2,035,000 төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн үйл ажиллагааг иргэдэд тэгш хүртээмжтэй, түргэн шуурхай нээлттэй ил тод мэдээллийг хүргэж үйлчилгээг үзүүлж байна. Ингэснээр иргэд төр болон хувийн хэвшлийн үйлчилгээг цаг хугацааг үл хамааран хялбар, хурдан нэг дороос авах боломж бүрдсэн.



Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэхээр “Төрийн цахим үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах”, “Цахимд зөв байя” “Кибер аюулгүй байдал” зэрэг сэдвийн хүрээнд 5025 төрийн албан хаагч, иргэд, ахлах ангийн сурагчдад сургалт зохион байгуулсан.



Иргэд цахим хуудаснаас мэдээлэл авахаас гадна мэдээллийн самбараас QR код уншуулах, ухаалаг дэлгэц ашиглан мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.



“Цахим үндэстэн-E-Nation” зорилтын хүрээнд мэдээллийн технологийн чиг үүрэг бүхий албан хаагчдын мэдлэг чадварыг сайжруулах замаар иргэд, төрийн албан хаагчдын цахим ур чадвар /тоон бичиг үсэг-Digital literacy/-ийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг төлөвлөн нийт 109 удаагийн сургалтыг зохион байгуулж 5025 иргэн, төрийн албан хаагчдад цахим ур чадварын сургалтыг зохион байгуулсан.





Тоон гарын үсэгтэй болох ажлыг эрчимжүүлэх үүднээс сургалтуудыг зохион байгуулж нийт 58 албан тушаалтнууд албан тушаалын тоон гарын үсэгтэй болж албан бичиг цахимаар боловсруулах боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр тоон гарын үсгээр баталгаажсан цахим албан бичиг солилцож байна.



Аймгийн хэмжээнд нийт 32044 иргэнд тоон гарын үсэг олгохоос Улсын бүртгэлийн хэлтсээс 25,418, Төрийн цахим үйлчилгээний хэлтсээс 624, нийт 26,042 иргэн буюу 81 хувьд олгоод байна.



Аймгийн хэмжээнд нутгийн захиргааны бүх байгууллага дотоод удирдлагын egr.e-mongolia.mn цахим системд холбогдож, үйл ажиллагаагаа тус системээр явуулж байна. Одоогийн байдлаар 84 байгууллагын 2734 төрийн албан хаагч тус системд бүртгүүлэн тогтмол ашиглаж байна.



Аймгийн төвд Төрийн цахим үйлчилгээний “ХУРДАН” гурван цэгийг шинээр байгуулж, цахим үйлчилгээний операторын системийн шинэчлэн 51 байгууллагын 471 лавлагаа тодорхойлолтыг цаасан болон цахим хэлбэрээр иргэдэд хүргэж ажиллаж байна.



Цахим шилжилтийн талаар “Цахим сум, байгууллага аян”-ыг зарлан сум, байгууллагуудтай хамтран ажиллах гэрээнд тусган ажиллахаас гадна аймгийн хэмжээнд 1 зорилт 15 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн.

Сошиал сүлжээний зохистой хэрэглээ №1

INSTAGRAM

e mongolia

- Өөрийн хаягаа private төлөвтэйгөөр ашиглах**
- 2 factor auth / 2 хүчин зүйлт баталгаажуулалтын тохиргоог идэвхжүүлэх**
- Үл таних дагагчдыг блок хийдэг байх**

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗАР

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний Цахим хөгжил, харилцаа, холбооны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг 99,3 хувь буюу “Үр дүнтэй” хэрэгжсэн гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Цахим хөгжилтэй холбоотой арга хэмжээнүүд нь үр дүнтэй хэрэгжиж байгаа нь аймгийн бодлогын баримт бичгүүд болон бүх шатны төрийн байгууллагын төлөвлөлтөд тусган үр дүнг тооцож ажиллахаас гадна мэдээлэл технологийн инженерийн ажлын ур чадвар, хариуцлага ихээхэн нөлөөлсөн гэж үзэж байна.

Гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс 13,183,767 төгрөгийг зарцуулсан байна.

Төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран 24/7 цагаар ажиллах ухаалаг төвд 2,035,000 төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн үйл ажиллагааг иргэдэд тэгш хүртээмжтэй, түргэн шуурхай нээлттэй ил тод мэдээллийг хүргэж үйлчилгээг үзүүлж байна. Ингэснээр иргэд төр болон хувийн хэвшлийн үйлчилгээг цаг хугацааг үл хамааран хялбар, хурдан нэг дороос авах боломж бүрдсэн.

Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэхээр “Төрийн цахим үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах”, “Цахимд зөв байя” “Кибер аюулгүй байдал” зэрэг сэдвийн хүрээнд 5025 төрийн албан хаагч, иргэд, ахлах ангийн сурагчдад давхардсан тоогоор 109 сургалтыг зохион байгуулан мэдээ мэдээллээр тогтмол хангаж ур чадвар дээшилсэн.

Сургалтад хамрагдагчдаас сургалтын өмнө болон дараах асуулга авч дүгнэхэд Мэдээллийн аюулгүй байдлаа хэрхэн хангах болон кибер аюулгүй байдлын талаар мэдлэг дутмаг байсан ба сургалтын дараах асуулгаар 90 гаруй хувь нь энэ талаар бүрэн мэдлэгтэй болсон ба цаашид мэдээллийн аюулгүй байдал болон кибер аюулгүй байдал, цахим залилангаас хэрхэн сэргийлэх талаарх мэдлэг ойлголттой болсон гэж үзэж болохоор байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Төрийн захиргааны удирдлагын хэлтэст:

1.Гэрээнд тусгагдсан үүргийн хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө суурь түвшин, хүрэх түвшин бодитой судалгаанд үндэслэн тодорхойлох

2.Гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг оны эхэнд unelgee.gov.mn төрийн мэдээллийн цахим системд оруулж баталгаажуулах

3. .Гэрээний хэрэгжилтийн тайланг ирүүлэхдээ шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшиндээ хүрсэн эсэх гарсан эцсийн үр дүн, үр нөлөөг тайлагнаж байх

Баталгаажуулсан:

Аймгийн Засаг дарга

С.Мөнхчулуун

Хянасан:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн

дарга

Д.Даариймаа

Тайлан бичсэн:

Хяналт шинжилгээ, үнэлгээний

хэлтсийн мэргэжилтэн

Л.Мягмармядаг